

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-7
1. “Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	4-7

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
11 дүгээр сарын 12-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 15 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: О.Саранчулуун;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Ж.Баярмаа, Э.Болормаа, А.Ганбаатар, Л.Гантөмөр, Ц.Даваасүрэн, Ч.Номин, Н.Номтойбаяр, Э.Одбаяр, Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл, Л.Энх-Амгалан, Д.Энхтуяа.

Нэг. “Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, референт А.Амармэнд, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, С.Эрдэнэболд нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Ц.Сандаг-Очир: “Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	17
Татгалзсан:	1
Бүгд:	18

94.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 10 минут үргэлжилж, 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр 18 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
18 цаг 15 минут.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ оройн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Батын Батбаатар гишүүн, Баярмагнайн Баярбаатар гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн, Тогмидын Доржханд гишүүн, Сархадын Зулпхар гишүүн, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн, Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн, Лхагвын Мөнхбаатар гишүүн, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Цэвэгдоржийн Туваан гишүүн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн, Бадарчийн Хэрлэн гишүүн, Өлзийхүүгийн Шижир гэсэн нийтдээ 17 гишүүн ирж, хуралдааны ирц 53,1 хувьтай байна. Байнгын хорооны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 асуудал хэлэлцэнэ.

“Монгол Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгүүлэх тухай” тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 96 дугаар тогтоолоор Д.Амарбаясгаланг Улсын Их Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлж, Улсын Их Хурлын даргыг шинээр сонгох хүртэл хугацаанд Улсын Их Хурлын даргын албан үүргийг хэрэгжүүлж байхыг Улсын Их Хурлын дэд дарга Хүрэлбаатарын Булгантуяад даалгасан.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар Хүрэлбаатарын Булгантуяаг Улсын Их Хурлын дэд даргаас огцруулж, Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг Улсын Их Хурлын дэд даргаар сонгосон тул Улсын Их Хурлын даргыг шинээр сонгох хүртэл хугацаанд Жадамбын Бат-Эрдэнээр “Улсын Их Хурлын даргын албан үүргийг гүйцэтгүүлэх тухай” тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгүүлэх тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас хурлаас тогтоох нь.

1.Монгол Улсын Их Хурлын даргыг шинээр сонгох хүртэл хугацаанд Улсын Их Хурлын даргын албан үүргийг гүйцэтгэж байхыг Улсын Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнэд даалгасугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төслийг уншиж танилцууллаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Шижир гишүүн асуулт, үг хамтдаа шүү.

Ө.Шижир: Бат-Эрдэнэ даргад оройн мэнд хүргэе. Та бас их албан тушаалын одтой хүн байна шүү. Нэг жил гарангын хугацаанд Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрх барьж байгаа намын дарга, бүлгийн дарга. Тэгээд одоо Улсын Их Хурлын дэд дарга.

Тэгээд бүлгээ 2 хуваачхаад, өөрөө дэд дарга болоод, сохорсон биш завшив гэдэг шиг л юм болж байх шиг байна. Тэгээд ямар ч байсан албан тушаалын одтой хүн байна.

Хамгийн том Байнгын хорооны дарга, хамгийн том эрх барьж байгаа намын бүлгийн дарга, одоо Улсын Их Хурлын дэд дарга. Тэгээд танд ямар ч байсан ажлын өндөр амжилт хүсье.

Ц.Сандаг-Очир: Үг хэлж байгаа юм байна. Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Бат-Эрдэнэ гишүүн Улсын Их Хурлын даргын үүргийг сонгогдтол нь гүйцэтгэнэ гэдэг бол үүрэг гүйцэтгэгч байна уу, үгүй юу гэдгээс хамаарч энэ ер нь парламентын засагтай холбоотой, парламентын дархлаатай холбоотой чухал хариуцлагатай манаанд зогсож байна гэсэн агуулга.

Сүүлийн 2 сарын хугацаанд манай улсын хууль тогтоох байгууллага, түүний үйл ажиллагааг, процессыг янз бүрээр тайлбарлах, улс төржиж талцсан хүмүүс хуулийг, тэр тусмаа Үндсэн хуулийг янз бүрийн байдлаар тайлбарлах зүйл хэрээс хэтэрсэн байна. Тэгэхээр та бас олон жил энэ төрд алба хашиж байгаа Их Хурлын гишүүний болон Засгийн газрын гишүүний тангараг өргөж байсан хүний хувьд одоо яг энэ дэд даргаар сонгогдоод, Улсын Их Хурлын даргын үүргийг гүйцэтгэх гэж байгаа энэ мөчид парламентын засаглал яагаад Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын 1.1.4-д заасан Үндэсний аюулгүй байдал тусгаар тогтнолын баталгаа болох тухай маш өндөр итгэл үнэмшилтэйгээр ажиллах шаардлагатай болж байгаа. Тэгэхээр энэ мөчид бас таны парламентын засаглалын тухай байр суурийг сонсмоор байна.

Өнгөрсөн хугацаанд бол нууц товчоо дээр гардаг шиг л орондоо унтах завгүй, олзлолдон булаалдаж байх энэ үед та бас тодорхой байр суурьтай байсан. Цаашлаад энэ парламентын дархлааг ахиулах, парламент ёсыг итгэл үнэмшилтэйгээр хамгаалж байх үүрэг бас танд тодорхой хугацаанд оногдож байна.

Тэгээд нэгэнт энэ тогтоол гарах гэж байгаа энэ цаг мөчид, хариуцлагатай цаг мөчид Монгол Улсын иргэдэд хандаж энэ парламентын дархлааны тухай итгэл үнэмшлийн тухай таны байр суурийг сонсмоор байна.

Ц.Сандаг-Очир: Эрдэнэболд гишүүний асуултад Бат-Эрдэнэ нэр дэвшигч. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Бас сая одтой, азтай гээд бас Шижир гишүүн маань нэг зүйл хэлэх шиг боллоо. Үүнтэй холбогдуулаад бас нэг зүйл хэлчихье гэж бодож байна.

Ер нь бол бүлгийн даргаар ажиллаж байсан энэ хугацаанд мэдээж бүлгийн гишүүдийнхээ юу санасан бодол, Улсын Их Хурлын гишүүний хувьд гаргаж байгаа санал, бодлыг нэгтгэх, энийг бас бүлгийн бодлого болгож гаргах, нэг байх гэсэн тал дээр мэдээж ажиллалгүй яах вэ. Тэгээд сая бол бид нарын хувьд бас их том алдаа гэх юм уу, алдаа бол гарлаа л даа. Тэгээд энэ утгаараа бүлэг маань бас хэд хэдэн саналууд гараад, санал хуваагдаад явсан ийм юм байгаа. Тэгэхдээ би бас тухайн үеийн, цаг үеийн бас тодорхой хэмжээний сэтгүүлчид хэлж байсан миний үгийг бол та бүхэн бас харсан байх. Ер нь бол бүлгийг аль болох нэгтгэх гэдэг тал дээр талуудыг хооронд нь эвтэй байх, гишүүд эв нэгдэлтэй байх, тодорхой 1 бодлого дээр нэгдмэл байх гэсэн талыг бол нэлээн баримталж ажилласан гэдгийг бас та бүхэнд хэлж байсан.

Таны асуултад хариулахад, ер нь бол парламентын засаглал гэдэг бол Монгол Улсын өнөөдөр аюулгүй байдлын том баталгаа гэж харж байдаг. Бид парламентын засаглалаа улам цааш нь төгөлдөржүүлэх, хүний эрхийг болоод нийт ард иргэдээс сонгогдож байгаа, ард иргэдээс сонгогдож баталгаа авч орж ирсэн гишүүний эрх, үүргийг баталгаажуулах, тэр гишүүнийхээ гаргаж байгаа саналыг бол нэг парламентын том санал болгоход гишүүн бүрийн саналыг хүндэтгэлтэйгээр хандах, ингээд цаашдаа бол парламентын засаглал бол ардчилсан нийгмийн хүрээнд улам хөгжиж, улам өргөжих нь бол зүй ёсны асуудал гэж боддог.

Монгол Улсын хувьд парламентын засаглалыг бол эргэлт буцалтгүйгээр сонгосон. Энэ тал дээрээ бол Үндсэн хуульдаа тунхагласан. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын төрийг барих дээд байгууллага бол парламент буюу Улсын Их Хурал байна гэж заасан байгаа. Тэгээд энэ утгаараа бол улсын хэмжээнд улсын төрийг барих асуудал бол парламентын засаглалтай улс орны хамгийн дээд, том эрх нь парламентын засаглалд байж байгаа. Тэгэхээр парламентын засаглалд байж байгаа Улсын Их Хурлын гишүүдийн эрх, үүрэг гэдэг бол асар том хариуцлагатай.

Өөрөөр хэлбэл энэ мандатыг авч, ард иргэдээс сонгогдож орж ирсэн энэ 126 гишүүн гэдэг үндсэндээ бол Монгол Улсыг төлөөлж байгаа парламентын засаглалын гол хүч нь юм л гэж би харж байгаа. Энэ утгаараа бол цаашдаа Монгол Улсын иргэнээс гарч байгаа санал, өөрсдийнхөө мандатаар дамжуулж Улсын Их Хуралд өөрсдийнхөө төлөөллийг гаргаж, тэндээсээ тодорхой төрийн бодлогыг барьж байх нь үндсэндээ парламентын засаглал юм гэдгийг хэлэх байна.

Ц.Сандаг-Очир: Болсон уу. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ. Энэ чинь яагаад болохгүй байна. Түрүүн Улсын Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулсан. Энэ уншсан тогтоолын төслийн дагуу тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 18 гишүүнээс 17 гишүүн дэмжиж, 94,4 хувиар санал дэмжигдлээ.

Саналын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хуралд миний бие өөрөө танилцуулаад явчихна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Баярлалаа.

18.25 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ